



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

**Цалин урамшууллын хорооны үйл
ажиллагааны журам батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн 2 дугаар зарчмын 2.3, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.27, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.5.3 дахь заалтууд, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журам батлагдсантай холбоотойгоор өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол мөрдөн, хэрэгжүүлж ажиллахыг Цалин урамшууллын хороо (Р.Мөнхтөр)-нд даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБЯАР

1524010102



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Эрсдэлийн сангийн журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Дүрмийн 5.7.22, 5.7.26 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 383 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 3.31 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 187 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа, төлбөр, тооцоо хийх ерөнхий журам”-ын 6.6 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Эрсдэлийн сангийн журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолоор баталсан “Эрсдэлийн сангийн журам”-ыг Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж, батламжлуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-т үүрэг болгосугай.
3. “Эрсдэлийн сангийн журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооноос батламжилсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1524910127



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

Г

Г

Гишүүнээр элсүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20, Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монсек ҮЦК” ХХК-ийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнээр элсүүлсүгэй.
2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын дагуу “Монсек ҮЦК” ХХК-тай “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ” байгуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.
3. Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг “Монсек ҮЦК” ХХК (М.Отгонбаатар)-д үүрэг болгосугай.
4. Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын системийн хөгжүүлэлт болон арилжаа эрхлэгч байгууллагын системтэй шаардлагатай холболтыг бүрэн хийж дуусгахыг “Монсек ҮЦК” ХХК (М.Отгонбаатар)-д даалгасугай.
5. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн гишүүн компанийн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1594010100



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

Гишүүнээр элсүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20, Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Куалити вэйлт брокер” ХХК-ийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнээр элсүүлсүгэй.
2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын дагуу “Куалити вэйлт брокер” ХХК-тай “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ” байгуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.
3. Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг “Куалити вэйлт брокер” ХХК (Л.Цогтсайхан)-д үүрэг болгосугай.
4. Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын системийн хөгжүүлэлт болон арилжаа эрхлэгч байгууллагын системтэй шаардлагатай холболтыг бүрэн хийж дуусгахыг “Куалити вэйлт брокер” ХХК (Л.Цогтсайхан)-д даалгасугай.
5. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн гишүүн компанийн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1594819100